



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/333

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үеийн ерөнхий үзүүлэлтийг тооцоолох аргачлалыг хавсралтаар баталсугай.

2. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрмийг мөрдлөг болгон гал түймэр унтраах дасгал сургуулалт, гал түймэр унтраах ажиллагаанд мөрдөн ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



9021120485
9129742 E C8717150

ГАРИУНБУЯН

0004361

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2022 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн
#333 дугаар тушаалын хавсралт



**АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН
ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

Нэг. Гал сөнөөгчид амьсгалын бие даасан төхөөрөмжтэйгээр гал түймрийн голомтод очих хүртэл хугацаанд зарцуулсан хамгийн дээд даралт: $P_{\text{мах.даралт}}$ (кгс/см²)

$$P_{\text{мах.даралт}} = \max(P_{1\text{даралт}}, P_{2\text{даралт}}, P_{3\text{даралт}}) \text{ /Жишээ: хүснэгт 1/}$$

Гал түймрийн голомт руу очих хугацаанд зарцуулсан даралт:

$$P_{\text{п.даралт}} = P_{\text{п.холб.үе}} - P_{\text{п.голомт}}$$

Тайлбар:

$P_{\text{п.даралт}}$ – Гал сөнөөгчийн зарцуулсан даралт (кгс/см²);

$P_{\text{п.холб.үе}}$ – n гал сөнөөгчийн амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж эхлэх үеийн даралт;

$P_{\text{п.голомт}}$ – n гал сөнөөгчийн галын голомтод очсон үеийн даралт;

Хүснэгт 1

Д/д	Гал сөнөөгч	АБДТ-ийг ашиглахын өмнөх үеийн даралт	Гал түймрийн голомтод очсон үеийн даралт	Зарцуулсан даралт	Зарцуулсан дээд даралт
1	№1	290	260	30	30
2	№2	280	255	25	
3	№3	270	250	20	

Хоёр. Гал сөнөөгчдийн утаажилтын бүсээс яаралтай гарах даралтын тооцоолол $P_{\text{гарах}}$ (кгс/см²)

Хэвийн нөхцөлд:

$$P_{\text{гарах}} = P_{\text{мах.даралт}} + \frac{1}{2} * P_{\text{мах.даралт}} + P_{\text{хавхлага}} = 1.5 * P_{\text{мах.даралт}} + P_{\text{хавхлага}}$$

Дунд болон түүнээс нөхцөлд:

$$P_{\text{гарах}} = P_{\text{мах.даралт}} + P_{\text{мах.даралт}} + P_{\text{хавхлага}} = 2 * P_{\text{мах.даралт}} + P_{\text{хавхлага}}$$

Тайлбар:

$P_{\text{хавхлага}}$ – агаараар хангах хавхлаганы хэвийн ажиллагаанд шаардлагатай даралт 10(кгс/см²).

$\frac{1}{2}$ болон 2 – хэвийн болон хүнд нөхцөлд урьдчилан таамаглах боломжгүй хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай агаарын нөөц;

Гурав. Гал сөнөөгчийн гал түймрийн голомтод ажиллах хугацаа, $T_{\text{аж}}$ (мин)

$$T_{\text{аж}} = \frac{(P_{\text{мах.даралт}} - P_{\text{гарах}}) * V_{\text{сав}}}{Q * \text{Каг.шах}}$$

Тайлбар:

Q – Агаарын дундаж зарцуулалт 40 л/мин. Ажлын ачааллын төрлөөс хамааран өөрчлөгдөж болно. /Жишээ: хүснэгт 2/

	Ажиллах нөхцөл	Агаар зарцуулалт л/мин
	Хэвийн	12,5
	Дунд	40
	Хүнд	60
	Маш хүнд	85

Дөрөв. Аюулгүй ажиллагааны хэсгээс амьсгалын бие даасан төхөөрөмжтэй утаажилтын бүсэд ажиллаж байгаа гал сөнөөгчдөд гарах дохио өгөх хугацааг тооцоолох;

$T_{\text{гарах}}(\text{цц:мм})$

$$T_{\text{гарах}} = T_{\text{голомт}} + T_{\text{аж}}$$

Тайлбар: $T_{\text{голомт}}$ – гал сөнөөгчид гал түймрийн голомтод очсон цаг;

Тав. Гал сөнөөгчид утаажилтын бүсэд ажиллах нийт хугацаа $\Delta T_{\text{нийт}}$ (мин)

$$\Delta T_{\text{нийт}} = \frac{(P_{\text{тндаралт}} - P_{\text{хавхлага}}) \cdot V_{\text{сав}}}{Q \cdot K_{\text{аг.шах}}}$$

Тайлбар:

$V_{\text{сав}}$ - Амьсгалын бие даасан төхөөрөмжийн агаар хадгалах савны эзлэхүүний хэмжээ;

$P_{\text{тндаралт}}$ – Амьсгалын бие даасан төхөөрөмжид холбогдох үеийн хамгийн бага даралт;

$K_{\text{аг.шах}}$ – Агаарын шахалтын коэффициент 1,1;

Зургаа. Гал сөнөөгчдийн утаажилтын бүсээс гарч ирэх цаг, $T_{\text{гарч.ирэх}}$ (цц:мм)

$$T_{\text{гарч.ирэх}} = T_{\text{холб}} + \Delta T_{\text{нийт}}$$

Тайлбар:

$T_{\text{холб}}$ – гал сөнөөгчдийн амьсгалын бие даасан төхөөрөмжид холбогдсон цаг.

Нэмэлт тайлбар: Хугацаа тооцсон томъёоны хариу бутархай гарсан тохиолдолд бүхэл хэсгийг авна.

$$\text{Жишээ нь: } T_{\text{аж}} = \frac{(P_{\text{тахдаралт}} - P_{\text{гарах}}) \cdot V_{\text{сав}}}{Q \cdot K_{\text{аг.шах}}} = \frac{(300 - 10) \cdot 6.8}{66} = 29,87 \approx 29 \text{ минут}$$